



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

2024 он

НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАГЦ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

(шинэчилсэн найруулга)



- Нийгмийн даатгалын ерөнхий хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль



**ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 4-р хороо,
Нэгдсэн Үндэстний гудамж-5 Улаанбаатар-15160



info@mlsp.gov.mn



+(976) 51-261553 /Бичиг хэрэг/

+(976) 51-261973 /Хэвлэлийн төлөөлөгч/

+(976) 11-328634 /Факс/



www.mlsp.gov.mn



[mlsp.gov.mn](https://www.facebook.com/mlsp.gov.mn)





УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ
2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ
ӨДРИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНААР
НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАГЦ
ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫГ
ХЭЛЭЛЦЭН БАТАЛЛАА.



Энэхүү багц хуулийн шинэчлэлийн агуулгыг
тоймлон Эрхэм танд хүргэж байна.





НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИЙН ТОО:



2023 оны 9-р сарын байдлаар



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ

Хуулийн зорилт: _____

Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар нийгмийн даатгалын төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоох, нийгмийн даатгалд даатгуулах, даатгуулагчийн санхүүгийн эрсдэлийг хуваалцах зорилгоор нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, хуваарилах, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавих, нийгмийн даатгалын үйл ажиллагаа, нийгмийн даатгалын байгууллагын эрх, үүргийг тодорхойлох харилцааг зохицуулна.

ШИНЭЭР МӨРДӨХ ЗОХИЦУУЛАЛТ



ХУРИМТЛАЛЫН ТОГТОЛЦООНД ШИЛЖИНЭ

ХУВААРИЛАЛТЫН ТОГТОЛЦОО

Эв санааны зарчимд
суурилсан тогтолцоо

1995-2023 он

ХУРИМТЛАЛЫН НЭГДСЭН САНТАЙ УЯЛДУУЛАХ

Хууль, эрх зүйн
шинэчлэл

2021-2024 он

ХАГАС ХУРИМТЛАЛЫН ТОГТОЛЦООНД ШИЛЖИХ

Нэрийн дансыг үе
шаттай мөнгөжүүлж,
хөрөнгө оруулалт
хийх

2024-2040 он

БҮРЭН ХУРИМТЛАЛЫН ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛЭХ

Бүрэн хуримтлалын
тогтолцоог
нэвтрүүлэх эхний үе
шат

2041-хойш

ТЭТГЭВРИЙН НӨӨЦ САН БҮРДҮҮЛНЭ

- Тэтгэврийн хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц санг бүрдүүлнэ:



Тэтгэврийн нөөц санд байршуулсан даатгуулагчийн мөнгөжүүлсэн орлогыг түүний саналд үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасан **санхүүгийн хэрэгсэлд** болон тухайлсан хуулиар зохицуулсан **эрүүл мэнд, боловсрол, орон сууцны ипотекийн** санхүүжилтэд хөрөнгө оруулж болно.



ТЭТГЭВРИЙН НӨӨЦ САНД БҮРДСЭН МӨНГӨЖҮҮЛСЭН ОРЛОГООС ӨВЛҮҮЛЭХ




Даатгуулагч нас барвал:

- түүний асрамжид байсан гэр бүлийн гишүүнд **тэжээгчээ алдсаны тэтгэвэр** тогтоож олгоно
- хэрэв тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч байсан гэр бүлийн гишүүн 19 нас хүрсэн, хөдөлмөрийн чадвар нь сэргээгдсэн, нас барсан бол мөнгөжүүлсэн орлого, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт олгосон **тэтгэврийн хэмжээний зөрүүг** тооцож хууль ёсны өв залгамжлагчид өвлүүлнэ
- хэрэв гэр бүлийн гишүүнд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэхгүй бол тэтгэврийн нөөц санд бүрдсэн мөнгөжүүлсэн орлогын тодорхой хувийг **хууль ёсны өв залгамжлагчид** өвлүүлнэ

ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ ТӨРӨӨС ХАРИУЦНА

- Сайн дураар даатгуулагч малчны **5 хүртэлх жилийн** тэтгэврийн даатгалын шимтгэлийн **50 хувийг төрөөс** төлнө.



- **Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа** ажил хөдөлмөр эрхлээгүй, нийгмийн даатгалын байгууллагатай сайн дураар даатгуулах гэрээ байгуулсан эх/эцгийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг **төрөөс бүрэн хариуцан** төлнө.



Жишээ: 2024 онд

660,000₮

ХХДХ*



11.5%

ШИМТГЭЛ*



75,900₮ сард

Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн ажил хөдөлмөр эрхэлж байгаа **тэтгэвэр авагч өөрөө хүсвэл тэтгэврийн даатгалд даатгуулахгүй байж болно.**

**тэтгэврийн даатгалд
даатгуулах бол**

19.3%-21.3%

**тэтгэврийн даатгалд
даатгуулахгүй бол**

2.3%-4.3%

тэтгэврийн даатгал

17%

тэтгэмжийн даатгал

1.8%

ҮОМШӨ-ний даатгал

0.5-2.5%

тэтгэмжийн даатгал

1.8%

ҮОМШӨ-ний даатгал

0.5-2.5%

ТЭТГЭВЭР АВАГЧ ӨӨРӨӨ СОНГОНО

ЦАЛИН ХӨЛСӨНД ХЭРЭГЛЭХ ИТГЭЛЦҮҮРИЙГ ЖИЛ БҮР ШИНЭЧЛЭН ТОГТООНО



жил бүрийн
08 ДУГААР САРЫН 01
ТОГТООНО

дараа жилийн
01 ДҮГЭЭР САРЫН 01
мөрдөнө

ШИМТГЭЛ ТӨЛӨХ ОРЛОГЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ ӨӨРЧИЛНӨ

- Нийгмийн даатгалд **сайн дураар даатгуулагчийн** шимтгэл ногдуулан төлөх сарын хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.

2023 онд

хөдөлмөрийн хөлсний
доод хэмжээг

10 ДАХИН

нэмэгдүүлсэнтэй тэнцүү



2024 оноос

хөдөлмөрийн хөлсний
доод хэмжээг

7 ДАХИН

нэмэгдүүлсэнтэй тэнцүү

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТӨЛӨХИЙГ ХОРИГЛОНО

- Нийгмийн даатгалын шимтгэлийг доорх тохиолдолд нөхөн төлүүлэх бөгөөд бусад тохиолдолд хориглоно.

1

ажил олгогч
нийгмийн даатгалын
шимтгэл ногдуулах
орлогыг нуусан
буюу хэмжээг
нь санаатайгаар
бууруулсан

2

ажил олгогч туайн
сардаа шимтгэлээ
төлөөгүй, эсхүл
дутуу төлсөн

3

сайн дураар
даатгуулах гэрээгээр
тохирсон хугацаанд
шимтгэлээ төлөөгүй

4

хууль бусаар ажлаас
халагдсан, хилс
хэргээр мөрдөгдсөн,
хилс хэргээр хорих
ял эдэлсэн тухай
шүүхийн шийдвэр
гарсан

АЖИЛ ОЛГОГЧ, ДААТГУУЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРГИЙГ ТОДОРХОЙ БОЛГОСОН

- Ажил олгогч, даатгуулагчийн эрх, үүргийг хуулиар нарийвчлан тодорхойлсон

Ажил олгогчийн эрх:

- 1 шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх
- 2 илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан авах, шилжүүлэн тооцуулах
- 3 нийгмийн даатгалын асуудлаар лавлагаа, тодорхойлолт, мэдээлэл, зөвлөгөө авах болон сургалтад хамрагдах
- 4 эрх бүхий байгууллагын шалгалтын дүн, акттай танилцах, тайлбар авах, өгөх
- 5 хууль зөрчсөн үйл ажиллагаа, шийдвэрийн талаарх гомдол гаргах
- 6 хууль тогтоомжид заасан бусад эрх

Ажил олгогчийн үүрэг:

- 1 ажилтантай хөдөлмөрийн гэрээ болон бусад гэрээ байгуулсан өдрөөс эхлэн түүнийг нийгмийн даатгалд даатгуулах
- 2 орон тоо болон цалин хөлсний бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр төлөх
- 3 анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, мэдээг дараа сарын 5-ны дотор хүргүүлэх
- 4 нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой баримт бичгийг тухай бүр нийгмийн даатгалын байгууллага, даатгуулагчид өгөх
- 5 эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тогтоосон акт, албан шаардлага, мэдэгдэл зэргийг хугацаанд нь биелүүлэх
- 6 ажил олгогчийн буруугаас даатгуулагчид учирсан хохирлыг бүрэн хариуцаж төлөх
- 7 ажилтныг нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллээр хангах
- 8 хууль тогтоомжид заасан бусад үүрэг

Даатгуулагчийн эрх:

- 1 тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авах
- 2 илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан авах, шилжүүлэн тооцуулах
- 3 нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, авсан тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн мэдээллийг цахим болон цаасан хэлбэрээр авах
- 4 нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн үндэслэлийг шалгуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хүсэлт гаргах
- 5 ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэл төлсөн эсэхэд хяналт тавих
- 6 ажил олгогчийн буруугаас шимтгэл нь төлөгдөөгүй, дутуу болон хугацаа хожимдож төлөгдсөн, баримт бичгийг хугацаанд нь гаргаж өгөөгүйн улмаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг авч чадаагүй, бүрэн аваагүй бол учирсан хохирол, зөрчигдсөн эрхээ сэргээлгэхэд гарсан зардлыг ажил олгогчоор төлүүлэх
- 7 тэтгэврийн нөөц сан дахь өөрийн мөнгөжүүлсэн орлогыг хөрөнгө оруулалтад оруулах эсэхийг сонгох
- 8 хууль тогтоомжид заасан бусад эрх

Даатгуулагчийн үүрэг:

- 1 тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авахад шаардлагатай баримт бичгийг үнэн зөв бүрдүүлэх
- 2 ажил олгогчийн нийгмийн даатгалын хууль тогтоомжийг зөрчсөн үйл ажиллагааны талаар холбогдох байгууллагад мэдээлэх
- 3 сайн дураар даатгуулагч гэрээнд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлээ төлөх
- 4 нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тогтоолт, олголтод хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, улсын байцаагчийн актаар тогтоосон төлбөрийг барагдуулах
- 5 хууль тогтоомжид заасан бусад үүрэг



НИЙГМИЙН ДААТГАЛЫН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНТАЙ БОЛНО

- Нийгмийн даатгалын байгууллага нь шимтгэл төлөгч, тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авагчийн, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны болон холбогдох бусад мэдээллийг агуулсан мэдээллийн нэгдсэн сантай болно.


НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТӨРӨЛ, ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

Албан журмын даатгуулагч		Сайн дураар даатгуулагч
Ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/	Даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/	Даатгуулагчийн өөрөө мэдүүлсэн орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/
▼	▼	▼
8.5	8.5	11.5
Тэтгэврийн даатгал	Тэтгэврийн даатгал	Тэтгэврийн даатгал
1.0	0.8	1.0
Тэтгэмжийн даатгал	Тэтгэмжийн даатгал	Тэтгэмжийн даатгал
0.5, 1.5, 2.5¹	-	1.0
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал
0.5	0.2	-
Ажилгүйдлийн даатгал	Ажилгүйдлийн даатгал	Ажилгүйдлийн даатгал
10.5, 11.5, 12.5	9.5	13.5
Шимтгэлийн дүн	Шимтгэлийн дүн	Шимтгэлийн дүн


¹ Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлага, эрсдэл бүхий ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлөөс хамаарна.



ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ



1991 он хүртэл Ажил олгоогч болон Даатгуулагч шимтгэл төлдөөгүй байсан.



ТЭТГЭВЭР АВАГЧИЙН ТОО:

492.4

мянга

ДУНДАЖ ТЭТГЭВЭР:



2023 оны 9-р сарын байдлаар



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Хуулийн зорилт: _____

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулиар Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасны дагуу тэтгэврийн даатгалд даатгуулж шимтгэл төлсөн даатгуулагчид тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр тогтоох, олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

ОЛОН ДАВХАРГАТ ТОГТОЛЦООНД ШИЛЖИНЭ

- Олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлж, даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авна.

1 ДАВХАРГА:

→ Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр



2 ДАВХАРГА:

→ Хувийн нэмэлт тэтгэвэр (сайн дурын үндсэн дээр)



ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭГ ЖИЛ БҮР НЭМЭГДҮҮЛНЭ

- Тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ.

жил бүрийн
01 дүгээр сарын
01-ний өдрөөс



ДААТГУУЛАГЧ ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭРТ ӨӨРИЙН СОНГОЛТООР ГАРНА

БҮРЭН ТЭТГЭВЭР:

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 2024 оны тухайд **21 жил 9 сар** ба түүнээс дээш хугацаанд төлсөн **60 насанд** хүрсэн эрэгтэй, **55 насанд** хүрсэн эмэгтэй өөрөө хүсвэл

1

2

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ **20-иос доошгүй** жил төлсөн төрсөн ондоо харгалзах насанд хүрсэн даатгуулагч өөрөө хүсвэл. Жишээлбэл, 20 жил шимтгэл төлсөн 1963 он (эмэгтэй 1968 он)-д төрсөн эрэгтэй даатгуулагч 61 нас 6 сар (эмэгтэй 56 нас 6 сар) насанд хүрсэн бол.

Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан **4 ба түүнээс дээш хүүхдээ 6 нас хүртэл өсгөсөн** тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-иос доошгүй жил төлсөн **50 насанд** хүрсэн эмэгтэй өөрөө хүсвэл

3

4

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20-иос доошгүй жил төлсөн, үүнээс **газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун** нөхцөлд 10-аас доошгүй жил ажиллаж **50 насанд** хүрсэн эрэгтэй, 7 жил 6 сараас доошгүй жил ажиллаж **45 насанд** хүрсэн эмэгтэй өөрөө хүсвэл

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20-иос доошгүй жил төлсөн, үүнээс **хөдөлмөрийн хүнд нөхцөлд** 12 жил 6 сараас доошгүй жил ажиллаж **55 насанд** хүрсэн эрэгтэй, 10-аас доошгүй жил ажиллаж **50 насанд** хүрсэн эмэгтэй өөрөө хүсвэл

5

6

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20-иос доошгүй жил төлсөн, үүнээс 15-аас доошгүй жил **малчнаар ажиллаж 55 насанд** хүрсэн эрэгтэй, 12 жил 6 сараас доошгүй жил **малчнаар ажиллаж 50 насанд** хүрсэн эмэгтэй өөрөө хүсвэл

Шимтгэл төлөх доод хугацааг хангаагүй даатгуулагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол төрсөн ондоо харгалзах насыг 28-29 хуудаснаас харна уу.

ХУВЬ ТЭНЦҮҮЛСЭН ТЭТГЭВЭР:

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ **10-20 хүртэл жил төлсөн** төрсөн ондоо харгалзах насанд хүрсэн даатгуулагч өөрөө хүсвэл.



Шимтгэл төлөх доод хугацааг хангаагүй даатгуулагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол төрсөн ондоо харгалзах насыг 28-29 хуудаснаас харна уу.

Шимтгэл төлөх доод хугацаа

(эрэгтэй 60/ эмэгтэй 55 насанд тэтгэвэрт гарах бол):

Тэтгэвэр тогтоолгох он	Шимтгэл төлсөн байвал зохиx доод хугацаа
2023	21 жил 6 сар
2024	21 жил 9 сар
2025	22 жил
2026	22 жил 3 сар
2027	22 жил 6 сар
2028	22 жил 9 сар
2029	23 жил
2030	23 жил 3 сар
2031	23 жил 6 сар
2032	23 жил 9 сар
2033	24 жил
2034	24 жил 3 сар
2035	24 жил 6 сар
2036	24 жил 9 сар
2037	25 жил

ЭРЭГТЭЙ даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас (шимтгэл төлөх доод хугацааг хангаагүй бол):

Эрэгтэй даатгуулагчийн төрсөн он	Өндөр насны тэтгэвэр тогтоох нас
1957 ба түүнээс өмнө	60 нас
1958	60 нас 3 сар
1959	60 нас 6 сар
1960	60 нас 9 сар
1961	61 нас
1962	61 нас 3 сар
1963	61 нас 6 сар
1964	61 нас 9 сар
1965	62 нас
1966	62 нас 3 сар
1967	62 нас 6 сар
1968	62 нас 9 сар
1969	63 нас
1970	63 нас 3 сар
1971	63 нас 6 сар
1972	63 нас 9 сар
1973	64 нас
1974	64 нас 3 сар
1975	64 нас 6 сар
1976	64 нас 9 сар
1977 ба түүнээс хойш	65 нас

ЭМЭГТЭЙ даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас (шимтгэл төлөх доод хугацааг хангаагүй бол):

Эмэгтэй даатгуулагчийн төрсөн он	Өндөр насны тэтгэвэр тогтоох нас	Эмэгтэй даатгуулагчийн төрсөн он	Өндөр насны тэтгэвэр тогтоох нас
1962 ба түүнээс өмнө	55 нас	1984	60 нас 6 сар
1963	55 нас 3 сар	1985	60 нас 9 сар
1964	55 нас 6 сар	1986	61 нас
1965	55 нас 9 сар	1987	61 нас 3 сар
1966	56 нас	1988	61 нас 6 сар
1967	56 нас 3 сар	1989	61 нас 9 сар
1968	56 нас 6 сар	1990	62 нас
1969	56 нас 9 сар	1991	62 нас 3 сар
1970	57 нас	1992	62 нас 6 сар
1971	57 нас 3 сар	1993	62 нас 9 сар
1972	57 нас 6 сар	1994	63 нас
1973	57 нас 9 сар	1995	63 нас 3 сар
1974	58 нас	1996	63 нас 6 сар
1975	58 нас 3 сар	1997	63 нас 9 сар
1976	58 нас 6 сар	1998	64 нас
1977	58 нас 9 сар	1999	64 нас 3 сар
1978	59 нас	2000	64 нас 6 сар
1979	59 нас 3 сар	2001	64 нас 9 сар
1980	59 нас 6 сар	2002 ба түүнээс хойш	65 нас
1981	59 нас 9 сар		
1982	60 нас		
1983	60 нас 3 сар		


ДАРААЛСАН 7 ЖИЛИЙГ 5 ЖИЛ БОЛГОНО

- Даатгуулагч дараалсан 5 жилийн дундаж цалин хөлснөөс тэтгэврээ тогтоолгоно.
- Дараалсан 6, 7 жилийн дундаж цалин хөлснөөс тэтгэврээ тогтоолгосон иргэдийн тэтгэврийг 5 жилийн дундаж цалин хөлснөөс тооцон өөрчлөн тогтооно.
- Дараалсан 6, 7 жилийн цалин хөлсөөр тэтгэврээ тогтоолгосон тэтгэврээ авагч 5 жилийн цалин хөлсөөр тэтгэврээ өөрчлөн тогтоолгох бол харьяа нийгмийн даатгалын байгууллагад хүсэлтээ гаргана.



ОЛОН ЖИЛ ШИМТГЭЛ ТӨЛӨХИЙГ УРАМШУУЛНА

- Олон жил шимтгэл төлж ажилласан даатгуулагч илүү өндөр тэтгэвэр авна.
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жилээс илүү төлсөн жил тутамд дундаж цалин хөлснөөс 1.5 хувиар тооцон нэмэгдүүлж байсан бол тэтгэврийг шимтгэл төлж ажилласан жил тутамд 2 хувиар (2029 оноос) тооцно;





20%

Гэр бүл болсноо
бүртгүүлж,
батлуулсан

20 ба түүнээс
дээш жил хамт
амьдарсан

ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВРИЙН ТУСГАЙ ЗОХИЦУУЛАЛТ

- Өндөр насны тэтгэвэр авагч нас барвал түүний авч байсан тэтгэврээс 20 хувиар тооцон нөхөр/эхнэрийн өндөр насны тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлнэ.

ТЭТГЭВЭР БОДОХ АРГЫГ СОНГОЛТТОЙ БОЛГОНО

ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР БОДОХ АРГА



1960.1.1-ний өдрөөс
өмнө төрсөн бол

ЦАЛИНД ҮНДЭСЛЭСЭН арга

(даатгуулагчийн
дараалсан 5 жилийн
дундаж цалин
хөлсийг шимтгэл
төлж ажилласан
жилд үндэслэн
тооцно)



1979.1.1-ний өдөр
ба түүнээс хойш
төрсөн бол

ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН НЭРИЙН ДАНСНЫ арга

(даатгуулагчийн
төлсөн шимтгэлийн
хэмжээнд үндэслэн
тооцно)

1960.1.1-ний өдрөөс
1979.1.1-ний өдөр хүртэл
хугацаанд төрсөн бол

АЛЬ НЭГ АРГЫГ ӨӨРӨӨ СОНГОНО

ТЭТГЭМЖ АВСАН ДААТГУУЛАГЧИЙН ТОО:

105.1

мянган хүн

Хөдөлмөрийн
чадвар алдсаны
тэтгэмж

46.1

мянган хүн

Жирэмсний
болон
амаржсаны
тэтгэмж

23.1

мянган хүн

Ажилгүйдлийн
тэтгэмж

10.6

мянган хүн

Оршуулгын
тэтгэмж



2023 оны 9-р сарын байдлаар



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Хуулийн зорилт: _____

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулиар Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн дагуу тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалд шимтгэл төлж даатгуулсан даатгуулагчид тэтгэмж олгох, тэтгэмжийн хэмжээ, хугацаа, ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

ШИНЭЭР МӨРДӨХ ЗОХИЦУУЛАЛТ



ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ НЭМЭГДЭНЭ

- Олон жил шимтгэл төлсөн даатгуулагчийн тэтгэмжийн хэмжээ нэмэгдэнэ



Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн хэмжээ:

ШИМТГЭЛ
ТӨЛСӨН хугацаа
(сараар)

3-60

61-120

121-180

**181 ба
түүнээс
дээш**



2023 ОН

ТЭТГЭМЖ
БОДОХ
хувь хэмжээ

50%

55%

-

75%



2024 ОНООС

50%

55%

60%

75%

132

өдрийн тэтгэмж



ТЭТГЭМЖ ОЛГОХ ХУГАЦААГ НЭМЭГДҮҮЛСЭН

- Хорт хавдар, сүрьеэгээр анх өвчилсөн, бөөрний хүнд хэлбэрийн дутагдал, эрхтэн шилжүүлэх мэс засал хийлгэсэн болон эрхтний донор даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хугацааны нэг удаагийн дээд хязгаар нэмэгдэж ажлын **132 өдрийн** тэтгэмж олгоно.



Ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ:

АЖИЛГҮЙДЛИЙН
ДААТГАЛЫН
ШИМТГЭЛ ТӨЛЖ
АЖИЛЛАСАН
ХУГАЦАА (сараар)

24-60

61-120

121-180

**181 ба
түүнээс
дээш**



2023 ОН

ТЭТГЭМЖ
БОДОХ
ХУВЬ ХЭМЖЭЭ

45%

50%

-

70%



2024 ОНООС

50%

55%

60%

70%



ИХЭР ХҮҮХЭД ТӨРҮҮЛСЭН БОЛ ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ НЭМЭГДЭНЭ



- Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг жирэмсний амралт авсан сарын өмнөх шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 100 хувиар тооцож, 120 хоногийн, ихэр хүүхэд төрүүлсэн бол 140 хоногийн хугацаанд тус тус олгоно.



- Жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодох хугацаанд нийтээр тэмдэглэх баярын өдөр тохиосон бол уг өдрийг ажлын өдөртэй адилтган тооцно.



АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ ДАХИН АВАХ НӨХЦӨЛ

- Урьд нь тэтгэмж авсан даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг 12 сар, үүнээс ажилгүй болохын өмнөх 3 сар тасралтгүй төлсөн бол ажилгүйдлийн тэтгэмж дахин авах эрх үүснэ.
- Ажилгүйдлийн тэтгэмж бодох хугацаанд нийтээр тэмдэглэх баярын өдөр тохиосон бол уг өдрийг ажлын өдөртэй адилтган тооцно.

12 сар



**Даатгуулагч
ажилгүйдлийн
тэтгэмж дахин
авах эрхтэй**



АЖИЛ ОЛГОГЧИД ҮЗҮҮЛЭХ ШИМТГЭЛИЙН ХӨНГӨЛӨЛТИЙН ХЭМЖЭЭ НЭМЭГДЭНЭ

- Даатгуулагчийг тогтвор суурьшилтай ажиллуулан 3 жил дараалан ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж гаргуулаагүй, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлсэн ажил олгогчийн сүүлийн жилд төлсөн ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн 15 хувиар тооцож, 3 жил тутамд нэг удаа шимтгэлийн хөнгөлөлт үзүүлнэ.

3 жил



Ажилтнаа
тогтвор
суурьшилтай
ажиллуулсан

Ажилгүйдлийн
даатгалын
сангаас
тэтгэмж
гаргуулаагүй



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САНГААС:

3.5

мянган хүн

Тахир дутуугийн
тэтгэвэр

462

хүн

Тэжээгчээ
алдсаны
тэтгэвэр

1.1

мянган хүн

Хөдөлмөрийн
чадвар түр
алдсаны
тэтгэмж,
хиймэл эрхтэн,
протезийн
төлбөр

1.2

мянган хүн

ҮОМШӨ-ний
сувиллын зардал

2023 оны 9-р сарын байдлаар



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Хуулийн зорилт: _____

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулиар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр тогтоох, олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

ШИНЭЭР МӨРДӨХ ЗОХИЦУУЛАЛТ



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ НЭМЭГДЭНЭ

- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн үйлчилгээ үзүүлж, тэднийг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэнэ.





УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН САЙЖИРНА

- Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн **тухайн жилийн шимтгэлийн орлогын 2 хувиас багагүй** байна.

АЖИЛ ОЛГОГЧ ҮОМШӨ-НИЙ ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ ЯЛГААТАЙ ТӨЛДӨГ БОЛНО

- “ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлага, эрсдэл бүхий ажлын байрны **хөдөлмөрийн нөхцөлөөс хамааралтайгаар** ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос **ялгаатай тогтооно**.

Тухайлбал, Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагын оффисын ажилтан ҮОМШӨ-ний даатгалын шимтгэл **2.5 %-аар** төлж байсныг **0.5% болгон бууруулсан**.

ПРОТЕЗ, ОРТОПЕДИЙН ЗАРДЛЫН ТӨЛБӨРИЙГ САН БҮРЭН ХАРИУЦНА

- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид протез, ортопедийн зардлын төлбөрийг жишиг үнийг баримтлан **эхний жилд 100%-аар, дараагийн удаа 50%-аар олгож байсныг 3 жил тутамд 100%-аар тооцож олгоно.**



АЖИЛ ОЛГОГЧИД ҮЗҮҮЛЭХ ШИМТГЭЛИЙН ХӨНГӨЛӨЛТИЙН ХЭМЖЭЭ НЭМЭГДЭНЭ

- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас зардал гаргуулаагүй ажил олгогчид 10%-ийн шимтгэлийн хөнгөлөлт үзүүлж байсныг 15% болгон нэмэгдүүлсэн. Дараах нөхцөлийг 3 жил дараалан хангасан ажил олгогчид хөнгөлөлт үзүүлнэ.



- Ажил олгогч нь үйлдвэрлэлийн ослын улмаас учирсан хохирлоо арилгах, хэвийн үйл ажиллагаагаа сэргээх зорилгоор сул зогссон хугацааны үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлээс чөлөөлөгдөнө.

МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БҮРДЭНЭ

Дараах мэдээллийг агуулсан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын мэдээллийн нэгдсэн сантай болно:



УЛС, ОРНУУДЫН ТЭТГЭВРИЙН НАС

№	Орон	Эрэгтэй	Эмэгтэй
1	Ecuador	70	70
2	Island	67	67
3	Italy	66.7	62.7
4	Barbados	66.6	66.6
5	Portugal	66	66
6	Ireland	66	66
7	United States	66	66
8	Netherlands	65.6	65.6
9	Argentina	65	60
10	Costa Rica	65	65
11	Bahamas	65	65
12	Brazil	65	60
13	British Virgin Islands	65	65
14	Chile	65	60
15	Cuba	65	60
16	Honduras	65	60
17	Jamaica	65	64.9
18	Canada	65	65
19	Peru	65	65
20	Saint Lucia	65	65
21	Hong Kong	65	65
22	Japan	65	65
23	Taiwan, China	65	65
24	Micronesia, Federated States	65	65
25	Albania	65	60
26	Andorra	65	65
27	Austria	65	60
28	Belgium	65	65
29	Bosnia and dHerzegovina	65	65
30	Croatia	65	61.5
31	Germany	65.5-67	65.5-67
32	Cyprus	65	65
33	Poland	65	60
34	Romania	65	60
35	Guernsey	65	65
36	Isle of Man	65	63
37	Monaco	65	55-65
38	Montenegro	65	60
39	Luxembourg	65	65
40	San Marino	65	65

41	Serbia	65	61
42	Slovenia	65	65
43	Spain	65	65
44	Switzerland	65	64
45	United Kingdom	65	63
46	Jersey	65	65
47	Liechtenstein	64	64
48	Finland	63-68	63-68
49	Bulgaria	63.10	60.10
50	Hungary	63.6	63.6
51	Lithuania	63.4	61.4
52	Azerbaijan	63	60
53	Czech Republic	63	62.4
54	Kazakhstan	63	58
55	Kyrgyzstan	63	58
56	Tajikistan	63	58
57	Estonia	63	63
58	Greece	62-67	62-67
59	Malta	62-65	62-65
60	Latvia	62.9	62.9
61	Norway	62	62
62	Slovakia	62	62
63	Монгол Улс /2024 онд/	61 нас 9 сар	56 нас 9 сар
64	France	61.7	61.7
65	Korea Republic	61	61
66	Lebanon	60-64	60-64
67	Algeria	60	55
68	Egypt	60	60
69	Morocco	60	60
70	Sudan	60	60
71	Tunisia	60	60
72	Angola	60	60
73	Benin	60	60
74	Burundi	60	60
75	Coba verde	60	60
76	Cameroon	60	60
77	Ethiopia	60	60
78	Sierra Leone	60	60
79	Tanzania	60	60
80	Togo	60	60
81	Antigua and Barbada	60	60
82	El Salvador	60	55

83	Guyana	60	60
84	Paraguay	60	60
85	Saint Vincent and the Grenadines	60	60
86	Uruguay	60	60
87	Venezuela, Bolivarian	60	55
88	Bahrain	60	55
89	Iraq	60	55
90	Jordan	60	55
91	Oman	60	55
92	Qatar	60	60
93	Syrian Arab Republic	60	55
94	Yemen	60	55
95	China	60	60
96	Myanmar	60	60
97	Philippines	60	60
98	Viet Nam	60	55
99	Iran, Islamic	60	55
100	Pakistan	60	55
101	Marshall Islands	60	60
102	Belarus	60	55
103	Russian Federation	60	55
104	Ukraine	60	57.6
105	Turkey	60	58
106	Uzbekistan	60	55
107	Nepal	58	58
108	Saudi Arabia	58	53
109	India	58	58
110	Australia	56	56
111	Bhutan	56	56
112	Indonesia	56	56
113	Brunei Darussalam	55	55
114	Singapore	55	55
115	Thailand	55	55
116	Sri Lanka	55	50
117	Samoa	55	55

УЛС, ОРНУУДЫН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

№	Орон	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ
1	Singapore	37.0
2	Italy	33.0
3	Uzbekistan	32.5
4	Brazil	29.5
5	Belarus	29.0
6	Moldova	29.0
7	Spain	28.3
8	Egypt	28.0
9	China	28.0
10	Czech Republic	28.0
11	France	27.8
12	Greece	26.5
13	Romania	26.2
14	Serbia	26.0
15	United Kingdom	25.8
16	Sudan	25.0
17	Tanzania	25.0
18	Azerbaijan	25.0
19	Tajikistan	25.0
20	Slovenia	24.4
21	Slovakia	24.4
22	Bosnia and dHerzegovina	24.0
23	Isle of Man	23.8
24	Kyrgyzstan	23.3
25	Paraguay	23.0
26	Austria	22.9
27	Portugal	22.7
28	Argentina	22.4
29	Finland	22.4
30	Viet Nam	22.0
31	Russian Federation	22.0
32	Ukraine	22.0
33	Hungary	21.8
34	Albania	21.6
35	San Marino	21.5
36	Norway	21.2
37	Syrian Arab Republic	21.1
38	Iran, Islamic	21.0
39	Montenegro	20.5
40	Latvia	20.0

41	Nepal	20.0
42	Sri Lanka	20.0
43	Andorra	20.0
44	Croatia	20.0
45	Malta	20.0
46	Turkey	20.0
47	Estonia	20.0
48	Poland	19.5
49	Germany	18.6
50	Japan	18.3
51	Ethiopia	18.0
52	Saudi Arabia	18.0
53	Netherlands	18.0
54	Bulgaria	17.8
55	Sweden	17.8
56	Jordan	17.5
57	Oman	17.5
58	Liechtenstein	17.4
59	Algeria	17.3
60	Монгол Улс	17.0
61	Togo	16.5
62	Belgium	16.4
63	Luxembourg	16.0
64	Leuxembourg	16.0
65	India	15.7
66	Cyprus	15.6
67	Cuba	15.5
68	Sierra Leone	15.0
69	Uganda	15.0
70	Uruguay	15.0
71	Bahrain	15.0
72	Qatar	15.0
73	Yemen	15.0
74	Micronesia, Federated States	15.0
75	Guyana	14.7
76	Guernsey	14.5
77	Libya	14.3
78	Colombia	14.1
79	Venezuela, Bolivarian	14.0
80	Iraq	14.0
81	Marshall Islands	14.0
82	Samoa	14.0
83	Nicargua	13.6
84	Ireland	13.6
85	Monaco	13.6
86	Peru	13.0

87	Chile	12.8
88	Barbados	12.7
89	Tunisia	12.5
90	Jersey	12.5
91	Congo	12.0
92	Island	12.0
93	Morocco	11.9
94	Dominica	11.8
95	Angola	11.0
96	Burkina Faso	11.0
97	Philippines	11.0
98	El Salvador	10.9
99	Canada	10.5
100	Benin	10.0
101	Burundi	10.0
102	Coba verde	10.0
103	Antigua and Barbada	10.0
104	Saint Kitts and Nevis	10.0
105	Saint Lucia	10.0
106	Saint Vincent and the Grenadines	10.0
107	Hong Kong	10.0
108	Brunei Darussalam	10.0
109	Bhutan	10.0
110	Kazakhstan	10.0
111	Bahamas	9.8
112	Ecuador	9.7
113	Australia	9.5
114	Costa Rica	9.3
115	Mali	9.0
116	Korea Republic	9.0
117	Lithuania	8.7
118	Lebanon	8.5
119	Switzerland	8.4
120	Cameroon	7.0
121	British Virgin Islands	6.6
122	Honduras	6.0
123	Myanmar	6.0
124	Thailand	6.0
125	Pakistan	6.0
126	Indonesia	5.7
127	Taiwan, China	5.1
128	Jamaica	5.0

НИЙГМИЙН ДААТГАЛЫН МЭДЭЭЛЭЛ АВАХ СУВАГ, ХОЛБОО БАРИХ УТАСНЫ ЖАГСААЛТ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР (НДЕГ)



Монгол Улс, 211238, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу 13/1



976-11-328030



undeg@ndaatgal.mn



<http://www.ndaatgal.mn>



sigomongolia

НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР (ННДГ)



Монгол Улс, 211238, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу 13/1



976-11-70141704



info@daatgal.ub.gov.mn



<http://www.daatgal.ub.gov.mn>

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ



Сөүл хот, Түндэмүн ёгса мунхуа буудлын 4 дүгээр гарц, замын эсрэг талд White horse байрны 9 давхар



02-2278-8030, 02-22-78-8034, 82-2-2278-8030



info@seoulcenter.mlsp.gov.mn



<https://seoulcenter.mlsp.gov.mn/>



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ЦАХИМ СУВГУУД:

- Төрийн үйлчилгээний цахим систем <https://e-mongolia.mn/>
- Нийгмийн даатгалын үйлчилгээний цахим систем <https://daatguulagch.ndaatgal.mn/>
- “Нийгмийн даатгал” аппликейшн
- Төрийн үйлчилгээний цахим машин (ТҮЦ машин) <https://tutsmashin.gov.mn/>

Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газартай холбоо барих утасны дугаар

1	Архангай аймаг	7507 9000
2	Баян-Өлгий аймаг	7042 2101
3	Баянхонгор аймаг	7044 4475
4	Булган аймаг	7034 2226
5	Говь-Алтай аймаг	7048 3483
6	Говьсүмбэр аймаг	7054 1289
7	Дархан-Уул аймаг	7705 7799
8	Дорнод аймаг	7758 5955
9	Дорноговь аймаг	7052 3223
10	Дундговь аймаг	7059 2309
11	Завхан аймаг	9546 2481
12	Орхон аймаг	7577 6699
13	Өвөрхангай аймаг	7032 2136
14	Өмнөговь аймаг	7053 3356
15	Сүхбаатар аймаг	7051 8915

16	Сэлэнгэ аймаг	7036 3087
17	Төв аймаг	7027 4004
18	Увс аймаг	7045 4805
19	Ховд аймаг	7509 1212
20	Хэнтий аймаг	7056 2212
21	Хөвсгөл аймаг	7038 2572
22	Багануур дүүрэг	7021 0021
23	Багахангай дүүрэг	7049 1151
24	Баянгол дүүрэг	7200 1289
25	Баянзүрх дүүрэг	7555 8484
26	Налайх дүүрэг	7023 2369
27	Сонгинохайрхан дүүрэг	7017 5959
28	Сүхбаатар дүүрэг	7000 4300
29	Хан-Уул дүүрэг	7510 3030
30	Чингэлтэй дүүрэг	7000 7790

